



**САНХҮҮГИЙН
ЗОХИЦУУЛАХ ХОРОО**
FINANCIAL REGULATORY COMMISSION
OF MONGOLIA

ДААТГАЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВАРТ ХИЙСЭН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

**УЛААНБААТАР ХОТ
2026 он**

АГУУЛГА

УДИРТГАЛ	3
НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ	4
1.1. Үнэлгээ хийх шалтгаан	4
1.2. Үнэлгээ хийх хүрээ	5
1.3. Үнэлгээний шалгуур үзүүлэлт	5
1.4. Үнэлгээний харьцуулах хэлбэр	6
1.5. Шалгуур үзүүлэлтийг томъёолох	6
1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох	6
ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ	6
ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ	7
3.1. Даатгалын салбарын өнөөгийн байдал	7
3.2. Хуулийн зорилт, үйлчлэх хүрээ, нэр томъёо /1-4 дүгээр зүйл/	8
3.3. Даатгалын ангилал, төрөл, хэлбэр /6 дугаар зүйл/	10
3.4. Давхар даатгал /46-48 дугаар зүйл болон холбогдох заалт/	12
3.5. Даатгалын маргаан шийдвэрлэлт /82, 82 ¹ дүгээр зүйл/	14
ДӨРӨВ. ДҮГНЭЛТ	16
ТАВ. АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ	18

УДИРТГАЛ

Монгол Улсын Их Хурлаас 1997 оны 12 сарын 05-ны өдөр Даатгалын тухай хуулийг 5 бүлэг, 23 зүйлтэй анх баталж, 2004 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр 17 бүлэг 85 зүйлтэйгээр хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан. Шинэчлэн батлагдсанаас хойш 21 жилийн хугацаанд нийт 17 удаа нэмэлт, өөрчлөлтийг оруулсан байна.

Хууль тогтоомжийн тухай хуульд 2017 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд уг хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3-т “Энэ хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийнэ” гэсэн нэмэлт орсон бөгөөд энэ хүрээнд Даатгалын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт тусгайлан үнэлгээ хийгдээгүй байна.

Иймд Даатгалын тухай хуульд Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу үнэлгээ хийж гүйцэтгэлээ.

Даатгалын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээ нь хуулийн хэрэгжилтийн явц дахь хүндрэл бэрхшээл, нийгэмд үзүүлж буй эерэг, сөрөг байдлыг тодорхойлох, цаашид зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлж, дүгнэлт зөвлөмж өгөх зорилготой.

Хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх ажил нь төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх гэсэн үндсэн гурван үе шатаас бүрдсэн болно.

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

Төлөвлөх үе шатанд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох;
- Үнэлгээ хийх хүрээг тогтоох;
- Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох;
- Харьцуулах хэлбэрийг сонгох;
- Шалгуур үзүүлэлтийг томъёолох;
- Мэдээлэл цуглуулах аргыг сонгох.

1.1. Үнэлгээ хийх шалтгаан

Даатгалын тухай хуулийг анх 1997 онд, хуулийн шинэчилсэн найруулгыг 2004 онд тус тус баталж, хүчин төгөлдөр мөрдөж байна.

Даатгалын тухай хууль батлагдан хэрэгжиж эхэлснээр даатгалын үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн үндэс бүрдэж, даатгалын зах зээлийн тогтвортой байдлыг хангах, даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах, даатгалын байгууллагын санхүүгийн чадавхыг бэхжүүлэх эрх зүйн орчин бүрдсэн. Хууль хэрэгжсэн хугацаанд санхүүгийн зах зээл, даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээний төрөл, хүртээмж, цахим технологийн хэрэглээ, олон улсын зохицуулалтын чиг хандлагад өөрчлөлт гарч, даатгалын салбарын үйл ажиллагаанд зохицуулалтын шинэ шаардлагууд үүсэж байна.

Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг “Алсын хараа-2050” Монгол улсын урт хугацааны хөгжлийн бодлогын Зорилт 4.3 “Олон улсын санхүүгийн зах зээлтэй холбогдсон олон тулгуурт, хүртээмжтэй санхүүгийн системийг хөгжүүлнэ” гэж тусгасан. Энэ зорилтын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 4.3.8. “Урт хугацааны даатгалын үйл ажиллагааны хууль, эрх зүйн орчныг сайжруулан, хүртээмжийг нэмэгдүүлнэ;” 4.3.9. Давхар даатгалын тогтолцоог боловсронгуй болгоно; 4.3.10. Технологид суурилсан даатгалын шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээний хууль, эрх зүйн орчныг боловсронгуй болгоно;” гэж, “Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн Үр дүнгийн 5.5.1.3.”Даатгалын хамрах хүрээг нэмэгдүүлнэ; 5.5.1.4. Давхар даатгалын хураамж хэлбэрээр гадагш гарч буй валютын урсгал буурна;” гэж, “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 3.1.3.1.Санхүү, даатгал, хөрөнгийн зах зээлийн хууль, эрх зүйн орчныг олон улсын жишигт нийцүүлэн шинэчилнэ” гэж тус тус заасан.

Түүнчлэн, Хууль тогтоомжийн тухай хуульд 2017 онд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд уг хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3-т “Энэ хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийнэ” гэсэн нэмэлт орсон бөгөөд энэ хүрээнд Даатгалын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт тусгайлан үнэлгээ хийгдээгүй байна.

Иймд Даатгалын тухай хуулийн зорилго, зорилт, зарчим, зохицуулалтын хэрэгжилтийн түвшин болон үр нөлөөг бодит мэдээлэл, судалгаанд үндэслэн үнэлэх

шаардлагатай байна. Энэхүү үнэлгээ Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагын дагуу Даатгалын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж, эрх зүйн зохицуулалтын үр нөлөө, үр ашиг, хэрэгжилтийн бодит нөхцөл байдлыг тогтоон, цаашид авах арга хэмжээний үндэслэлийг боловсруулах зорилготой болно.

1.2. Үнэлгээ хийх хүрээ

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын зургаадугаар хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-ын 3.3.1-д “үнэлгээний хүрээг тогтоох ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх хамгийн гол зохицуулалтыг тодорхойлоход чиглэнэ” гэж заасан. Иймд үнэлгээний хүрээг тогтоохдоо дээрх шалгуур үзүүлэлтийг үндэслэн хуулийн зорилго, салбарын гол эрсдэл, хэрэглэгчийн эрх ашиг, даатгагчийн санхүүгийн тогтвортой байдал, хяналт зохицуулалтын үр нөлөөг харгалзан дараах зохицуулалтыг сонгож, үнэлгээг хийж гүйцэтгэлээ.

№	Үнэлэх зохицуулалт	Хамаарах зүйл	Сонгосон үндэслэл
1	Хуулийн зорилт, үйлчлэх хүрээ, нэр томьёо	1-4 дүгээр зүйл	Хуулийн зорилго өнөөгийн зах зээлийн бүтэц, цахим үйлчилгээ, шинэ бүтээгдэхүүнтэй нийцэж байгаа эсэх
2	Даатгалын ангилал, төрөл, хэлбэр	6 дугаар зүйл	Урт хугацааны/ердийн, сайн дурын/албан журмын даатгалын ангилал/төрөл/хэлбэр бодит хэрэгцээнд нийцэж байгаа эсэх
3	Давхар даатгал	46-48 дугаар зүйл	Эрсдэл шилжүүлэх, гадаадын давхар даатгал, валютын эрсдэл, давхар даатгалын төлөвлөгөөний хяналт
4	Даатгалын маргаан шийдвэрлэлт	82 дугаар зүйл	Даатгалын үйл ажиллагаатай холбоотой маргааныг шийдвэрлүүлэх ажиллагаа

1.3. Үнэлгээний шалгуур үзүүлэлт

Аргачлалын дагуу Даатгалын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврыг үнэлэхэд оновчтой, бодитой, хэмжиж болохуйц байдлыг баримталж, мөн үнэлгээний хамрах хүрээ, онцлогоос хамааран дараах хоёр шалгуур үзүүлэлтийг сонгосон. Үүнд:

1.Зорилгод хүрсэн түвшин: Хуулийн хэрэгжилтийн үр дагаварт бүхэлд нь үнэлгээ хийх зорилгод хүрсэн түвшин шалгуур үзүүлэлтийг хэрэглэх нь тохиромжтой байдаг. Энэхүү онцлог нь тус үнэлгээний зорилгод нийцэж байгаа болно.

2.Практикт нийцэж байгаа байдал: Тус шалгуур үзүүлэлтийн хүрээнд Даатгалын тухай хуулийн холбогдох зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байгаа,

түүний эерэг, сөрөг үр дагавар, хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл гарч байгаа эсэхийг тогтооно.

1.4. Үнэлгээний харьцуулах хэлбэр

Хууль тогтоомж хэрэгжсэнээр нийгмийн харилцаанд гарсан эерэг, сөрөг өөрчлөлтүүдийг олж тодорхойлоход харьцуулах хэлбэрүүдийг ашигладаг.

Энэхүү үнэлгээнд аргачлалын 3.5.3 дахь хэсэгт заасан дөрвөн төрлийн харьцуулах хэлбэрүүдээс “хууль тогтоомж хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлснээс хойш” болон “тохиолдол судлах” хэлбэрийг тус тус сонголоо.

Харьцуулах хэлбэр	Хэрэглэх байдал
Хууль хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш	Салбарын тоон үзүүлэлт, бүтэц, гомдол маргааны чиг хандлагыг сүүлийн 5 жилийн байдлаар, он дарааллаар харьцуулах
Тохиолдол судлах	Нэр томьёо ба шинэ бүтээгдэхүүн, даатгалын ангилал, давхар даатгал, нөхөн төлбөрийн маргаан зэрэг төлөөлөх кейсийг сонгон практикт гарч буй нийцэл, хүндрэл, үр дагаврыг шинжлэх.

1.5. Шалгуур үзүүлэлтийг томьёолох

“Шалгуур үзүүлэлтийг томьёолох” гэдэг нь сонгосон шалгуур үзүүлэлт тус бүрээр тодорхой таамаглал дэвшүүлэх буюу асуулт тавьдаг бөгөөд үнэлгээний хүрээнд хамаарах зохицуулалтад дор дурдсан асуултын хүрээнд үнэлгээг гүйцэтгэлээ.

Шалгуур	Томьёолсон асуулт
Зорилгод хүрсэн түвшин	Хууль даатгалын үйл ажиллагааны эрх зүйн үндэс, хяналт зохицуулалт, тусгай зөвшөөрөл олголт, даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах зорилгодоо хүрсэн эсэх
Практикт нийцэж байгаа байдал	Хуулийн зохицуулалт хэрэгжих явцад ойлгомжгүй, давхардалтай, хийдэлтэй, эсхүл зах зээлийн шинэ нөхцөл, хөгжлийн чиг хандлагаас хоцорсон эсэх

1.6. Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

Энэхүү ажлын хүрээнд үнэлгээ хийх хуулийн зүйл, хэсгийн зорилгод хүрсэн түвшин, практик хэрэгжилтийг илрүүлэх зорилгоор Даатгалын тухай хууль шинэчлэн батлагдсанаас хойших хугацааны бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг судлах, жил бүрийн санхүүгийн тайлан, статистик тоон мэдээллийг судлах, харьцуулалт хийх аргыг ашиглана. Мэдээлэл цуглуулах аргын хувьд “Байгаа мэдээллийг цуглуулж ашиглах” аргыг сонгон хэрэгжүүлээ.

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Даатгалын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх мэдээллийг цуглуулахдаа баримт бичгийн судалгаа, харьцуулсан судалгааны аргад тулгуурлан гүйцэтгэв. Үүнд:

- Баримт бичгийн судалгаа: Холбогдох хууль тогтоомж, даатгалын салбарын жил бүрийн санхүүгийн тоо мэдээ, түүний нэгтгэл тайланг цуглуулж ашигласан болно.
- Харьцуулсан судалгаа: Хөгжлийн түвшин ижил төстэй улс, орнуудын сайн туршлага, мэдээллийг харьцуулалт хийх зорилгоор цуглуулж ашиглалаа.

Цуглуулж ашигласан мэдээллийг “Ашигласан эх сурвалж”-ийн мэдээллийн жагсаалтаар харууллаа.

ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Энэ үе шатанд Даатгалын тухай хуулийн дээр дурдсан зүйл, хэсгүүдийг сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлнэ.

3.1. Даатгалын салбарын өнөөгийн байдал

2025 оны байдлаар Монгол Улсын даатгалын зах зээл дээр тусгай зөвшөөрөл бүхий ердийн даатгалын 18, урт хугацааны даатгалын 3, давхар даатгалын 1 компани, 63 даатгалын зуучлагч (үүнээс банк зуучлагч 9), 29 даатгалын хохирол үнэлэгч, 1143 даатгалын төлөөлөгчөөс гадна даатгалын актуарч, аудитор зэрэг 200 гаруй даатгалын мэргэжлийн оролцогчид үйл ажиллагаа явуулж байна.

Хүснэгт 1. Даатгалын зах зээлийн оролцогчид

№	Даатгалын зах зээлийн оролцогчид	2025.12.31
1	Даатгалын компанийн тоо	22
2	Үүнээс: ердийн даатгалын компани	18
3	Үүнээс: урт хугацааны даатгалын компани	3
4	Үүнээс: давхар даатгалын компани	1
5	Даатгалын зуучлагч компанийн тоо	63
6	Даатгалын хохирол үнэлэгч компанийн тоо	29
7	Аудитын компанийн тоо	47
8	Аудиторын тоо	153
9	Актуарчийн тоо	40
10	Даатгалын төлөөлөгчийн тоо	1143


Даатгалын байгууллагууд нь даатгалын компанийн 234, даатгалын зуучлагч компанийн 425, даатгалын хохирол үнэлэгч компанийн 94 салбар, төлөөлөгчийн газраар дамжуулан үйл ажиллагаа явуулж, нийт 797 даатгалын бүтээгдэхүүн (нэг компани дунджаар 30 гаруй даатгалын бүтээгдэхүүн) үйлчилгээг хүргэж, жилдээ иргэд, байгууллагуудын 400 гаруй их наяд төгрөгийн үнэлгээ бүхий эрсдэлийг даатгаж байна.

Сүүлийн 5 жилийн статистик мэдээллээс харахад даатгалын салбарын голлох үзүүлэлт болох нийт хөрөнгийн хэмжээ жилд дунджаар 18 хувиар, даатгалын хураамж, нөхөн төлбөр дунджаар 23-25 хувиар тус тус тогтмол өссөн байх бөгөөд 2025 оны байдлаар голлох үзүүлэлтүүдийг дурдвал:

2025 оны байдлаар даатгалын компаниудын нийт хөрөнгө 771.3 тэрбум төгрөгт хүрсэн ба өмнөх оны мөн үеэс 16.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Даатгалын компаниудын нийт хөрөнгөд эзлэх хувийг даатгагчийн төрлөөр авч үзвэл ердийн даатгалын компаниудын нийт хөрөнгө 674.4 тэрбум төгрөг, урт хугацааны

даатгалын компаниудын нийт хөрөнгө 29.1 тэрбум төгрөг, давхар даатгалын компанийн хөрөнгө 67.8 тэрбум төгрөг байна.

Зураглал 1. Даатгалын компаниудын нийт хөрөнгийн хэмжээ /сая.төг/



Түүнчлэн, даатгалын компаниудын нөөц сан өмнөх оны мөн үеэс 4.6 хувиар өсөж, 361.1 тэрбум төгрөгт хүрсэн бөгөөд үүний 319.3 тэрбум төгрөгийг ердийн даатгалын компаниудын, 34.6 тэрбум төгрөгийг давхар даатгалын компанийн, 7.2 тэрбум төгрөгийг урт хугацааны даатгалын компанийн нөөц сан бүрдүүлж байна.

Тайлант хугацаанд ердийн болон урт хугацааны даатгалын компаниуд 390.1 их наяд төгрөгийн эрсдэлийг хүлээн авч, 584.6 тэрбум төгрөгийн даатгалын нийт хураамжийн орлоготой ажиллаж, давхар даатгалын хураамжийн зардалд 195.5 тэрбум төгрөгийг шилжүүлсэн бол ердийн болон урт хугацааны даатгалын компаниудын олгосон нийт нөхөн төлбөр 193.7 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Даатгалын хураамжийн орлого болон нөхөн төлбөрийг даатгалын хэлбэрээр авч үзвэл, ердийн даатгалын нийт хураамжийн дүнд хөрөнгийн даатгал хамгийн өндөр буюу 25.5 хувийг эзэлж байгаа бол авто тээврийн хэрэгслийн даатгал 24.2 хувь, гэнэтийн осол, эмчилгээний даатгал 17.6 хувь, жолоочийн хариуцлагын даатгал 10.4 хувь, хариуцлагын даатгал 10.2 хувь, бусад даатгалын хэлбэр 12.1 хувийг эзэлж байна. Харин даатгалын нөхөн төлбөрийн хувьд автотээврийн хэрэгслийн даатгал хамгийн өндөр буюу 26.3 хувийг эзэлж байгаа бол жолоочийн хариуцлагын албан журмын даатгал 25.3 хувь, гэнэтийн осол, эмчилгээний даатгал 23.9 хувь, барилга угсралтын даатгал 9.7 хувь, бусад даатгалын хэлбэр 14.8 хувийг эзэлж байна.

Урт хугацааны даатгалын хувьд даатгалын хураамжийн орлогын 33.8 хувийг хугацаат амьдралын даатгал эзэлж байгаа бол даатгалын нөхөн төлбөрийн хувьд мөн эрүүл мэндийн даатгал 41.5 хувийг тус тус эзэлж байна.

3.2. Хуулийн зорилт, үйлчлэх хүрээ, нэр томьёо /1-4 дүгээр зүйл/

3.2.1. Зохицуулалтын агуулга

Хуулийн 1 дүгээр зүйлд хуулийн зорилтыг даатгалын үйл ажиллагаа явуулах эрх зүйн үндсийг тогтоох, төрийн эрх бүхий байгууллагаас даатгалын үйл ажиллагааг зохицуулах, хяналт тавих, тусгай зөвшөөрөл олгох, даатгуулагчийн эрх ашгийг хамгаалахтай холбоотой харилцааг зохицуулах гэж тогтоосон.

3 дугаар зүйл нь хуулийн үйлчлэх хүрээг ялган тогтоож, даатгалын ерөнхий үйл ажиллагаанд хамаарах харилцааг энэ хуулиар, харин нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгал, даатгагч-даатгуулагчийн гэрээний харилцаа, даатгалын мэргэжлийн оролцогч, хадгаламжийн даатгал, малын индексжүүлсэн даатгал зэрэг тусгай харилцааг холбогдох хуулиар зохицуулахаар заасан.

4 дүгээр зүйл нь “даатгалын үйл ажиллагаа”, “даатгагч”, “даатгуулагч”, “даатгалын тохиолдол”, “даатгалын хураамж”, “даатгалын нөхөн төлбөр”, “даатгалын багц дүрэм”, “актуарч”, “давхар даатгалын үйл ажиллагаа” зэрэг салбарын суурь ойлголтыг тодорхойлсон.

3.2.2. Зорилгод хүрсэн түвшин

Энэ зохицуулалт нь салбарын эрх зүйн суурь ойлголтыг тогтоосон тул даатгалын үйл ажиллагаа эрхлэх этгээдийг тодорхойлох, тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих, даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах дараагийн зохицуулалтуудын үндэс болж байна. Даатгалын зах зээлд тусгай зөвшөөрөлтэй даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид, төлөөлөгчийн бүтэц бий болж, хяналт зохицуулалтын тогтолцоо ажиллаж байгаа нь хуулийн зорилтын суурь хэрэгжилтийг харуулж байна.

Гэхдээ хуулийн зорилт нь өргөн хүрээтэй боловч даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах агуулга нь даатгуулагчийн мэдээлэл авах эрх, өргөдөл, гомдол шийдвэрлэх хугацаа, нөхөн төлбөрийн ил тод байдлын түвшинд хуульд нарийвчилсан байдлаар тусгагдаагүй байна. Мөн техник технологийн хөгжил, даатгалын салбарын цахимжилттай холбоотойгоор даатгалын үйл ажиллагаа, үйлчилгээг даатгуулагчдад ойртуулах, зардлыг бууруулах боломж нээгдээд байгаа боловч өнөөгийн хууль эрх зүйн хүрээнд даатгалын гэрээ байгуулах, даатгалын нөхөн төлбөр нэхэмжлэх үйл явцад баримт бичгийг заавал бичгээр үйлдэх, баталгаажуулах шаардлагууд хэвээр үйлчилсээр байна. Иймээс даатгалын салбарын оролцогчдод цахим дэвшилтэд техник технологид суурилсан даатгалын үйлчилгээ үзүүлэх боломжийг бүрдүүлж, хөгжүүлэх эрх зүйн орчныг бий болгох шаардлагатай байна.

Иймд хуулийн зорилго биелсэн боловч түүнийг хэрэгжүүлэх механизмын зарим хэсгийг илүү тодорхой болгох шаардлагатай гэж дүгнэж байна.

3.2.3. Практикт нийцэж байгаа байдал

Практикт хуулийн нэр томьёо нь даатгалын уламжлалт бүтээгдэхүүн, тусгай зөвшөөрөл, даатгалын гэрээ, хураамж, нөхөн төлбөрийн зохицуулалтад хэрэглэгдэх боломжтой байна. Гэвч даатгалын салбарын цахимжилттай холбоотойгоор нэвтэрч буй цахим даатгалын гэрээ, цахим баталгаа, цахим дэвшилтэд техник технологид суурилсан даатгалын үйлчилгээ, даатгагчийн баталгаа, ногоон даатгал, хүртээмжтэй даатгал зэрэг салбарт нэвтэрсэн шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой нэр томьёог хуульд тусгах нь зүйтэй байна.

Хуулийн үйлчлэх хүрээнд даатгалын мэргэжлийн оролцогчийн харилцааг тусгай хуулиар зохицуулах, даатгагч-даатгуулагчийн гэрээний харилцааг Иргэний хуулиар зохицуулах гэж заасан нь салбар хоорондын эрх зүйн хуваарилалтыг тодорхой болгосон давуу талтай. Харин даатгуулагчийн эрх ашгийг хамгаалахтай холбоотойгоор даатгалын бүтээгдэхүүний талаарх мэдээллийг даатгуулагч нарт өгөхтэй холбоотой харилцаа, цахим даатгалын гэрээний баталгаажуулалт, нөхөн төлбөрийн маргаан зэрэг хуульд илүү нарийвчлан тусгах нь зүйтэй байна.

Асуудал	Одоогийн зохицуулалт	Практикт үүсэх эрсдэл	Сайжруулах чиглэл
Цахим даатгал	Нэр томьёонд шууд тусгагдаагүй; холбогдох журам, цахим гарын үсэг, цахим баримт бичгийн зохицуулалтаар хэрэгжих боломжтой.	Гэрээ байгуулагдсан эсэх, хэрэглэгч мэдээлэл авсан эсэх, цахим баталгааны хүчин төгөлдөр байдлын маргаан үүсэх магадлалтай.	Цахим даатгалын үйлчилгээ, цахим баталгаа, цахим борлуулалтын үндсэн зарчмыг нэр томьёо/ерөнхий зохицуулалтаар тодруулах.
Даатгагчийн баталгаа	Хуулийн нэмэлт зохицуулалтаар тодорхой харилцаанд баталгаа гаргах боломж бий болсон.	Даатгалын үйл ажиллагаа болон баталгааны бүтээгдэхүүний зааг, нөөц сан, давхар даатгал, эрсдэлийн үнэлгээний уялдаа тодорхой бус байж болзошгүй.	Даатгагчийн баталгаа, түүнд хамаарах эрсдэлийн сан, давхар даатгалын шаардлагыг нэр томьёо, хяналтын түвшинд тодорхойлох.
Даатгуулагчийн эрх ашиг	Хуулийн зорилтод туссан боловч хэрэглэгчийн мэдээлэл авах эрх, гомдол шийдвэрлэх хугацаа зэрэг харилцаа хуульд тодорхой бус.	Даатгуулагч даатгалын нөхцөл, хасалт, нөхөн төлбөрийн үндэслэл, гомдол гаргах эрхээ бүрэн ойлгохгүй байх эрсдэлтэй.	Даатгуулагчид өгөх урьдчилсан мэдээлэл, гэрээний гол нөхцөлийн тайлбар, гомдол гаргах сувгийн мэдээллийг хуульд суурь зарчим байдлаар тусгах.

3.3. Даатгалын ангилал, төрөл, хэлбэр /6 дугаар зүйл/

3.3.1. Зохицуулалтын агуулга

6 дугаар зүйлд даатгалыг урт хугацааны болон ердийн даатгал гэж ангилж, даатгал нь сайн дурын болон албан журмын гэсэн төрөлтэй байхаар зохицуулсан. Албан журмын даатгалын хэлбэрийг хуулиар тогтоох, албан журмын даатгалын эрсдэл, нөхцөлийн нарийвчилсан зохицуулалтыг тухайн албан журмын даатгалыг

заавал даатгуулах даатгал гэж тодорхойлсон хуулиар зохицуулах, сайн дурын даатгалын хэлбэрийг Санхүүгийн зохицуулах хороо тогтоохоор заасан.

3.3.2. Зорилгод хүрсэн түвшин


Даатгалын ангилал, төрөл, хэлбэрийн зохицуулалт нь зах зээлийн бүтээгдэхүүний суурь бүтцийг тогтоож, тусгай зөвшөөрөл, бүтээгдэхүүний бүртгэл, тайлагнал, хяналт шалгалт, нөөц сан, төлбөрийн чадварын зохицуулалтад ялгаатай байдлаар хяналт, зохицуулалт хийх үндсэн үүргийг гүйцэтгэж байна. Урт хугацааны болон ердийн даатгалын ялгаа нь даатгагчийн хөрөнгө, нөөц, актуар тооцоо, урт хугацааны сан, бүтээгдэхүүний зохицуулалтад чухал ач холбогдолтой.

Сайн дурын болон албан журмын даатгалын ялгаа нь төрийн оролцоо, хураамж, бүтээгдэхүүний нөхцөл, даатгуулах үүрэг, хяналтын арга хэрэгслийг ялган тогтоох боломжийг бүрдүүлсэн. Иймд зорилгод хүрсэн түвшний хувьд уг зохицуулалт салбарын суурь ангиллыг хангаж байна гэж үнэлэв.

3.3.3. Практикт нийцэж байгаа байдал

Монгол улсын даатгалын салбарын өнөөгийн нөхцөл байдлыг бүтэц, төвлөрлийн хувьд дүгнэн харвал, ердийн даатгал давамгайлсан буюу нийт хураамжийн орлогын 99 хувийг ердийн даатгалын хураамж эзэлж байгаа бол урт хугацааны даатгалын хувьд ердөө 1 орчим хувийг эзэлж байна. /*Зураглал 2. Даатгалын хураамжийн орлогын бүтцийг харуулав.*/ Гэтэл даатгалын зах зээл өндөр хөгжсөн орнуудын хувьд урт хугацааны даатгал 55 орчим хувийг эзэлдэг статистик үзүүлэлт байна.

Зураглал 2. Даатгалын хураамжийн орлогын бүтэц



Урт хугацааны буюу амьдралын даатгал нь хүний амь нас, эрүүл мэндэд эрсдэл учирсан үед даатгалын нөхөн төлбөр олгож, даатгуулагчийн орлогыг тасалдалгүй байлгах, улмаар даатгуулагчийн гэр бүлийн санхүүгийн тогтвортой байдлыг баталгаажуулах, түүнчлэн ирээдүйн мөнгөн хуримтлалыг бий болгох хөрөнгө оруулалтын хэрэгсэл болох зэрэг үүргийг гүйцэтгэдэг ач холбогдол бүхий даатгал байдаг боловч энэхүү даатгалын бүтээгдэхүүний хамралт, иргэд, даатгуулагчдын энэ бүтээгдэхүүний хэрэгцээ шаардлагын талаарх ойлголт

төдийлөн хангалттай бус байгааг дээрх мэдээллээс харж болно.

Энэ нь нэг талаас иргэд даатгуулагчдын даатгалын ач холбогдлын талаарх ойлголт хангалтгүй байгаатай холбоотой бол, нөгөө талаас хууль тогтоомжийн тодорхойгүй байдлаас шалтгаалан үүсэж байна. Өөрөөр хэлбэл, Даатгалын тухай хуулиар даатгалыг ердийн болон урт хугацааны даатгал гэж ангилсан боловч тэдгээрийн ялгааг хуулиар нарийвчлан зохицуулаагүй нь даатгуулагч даатгалын гэрээг буруу ойлгох, даатгалын тохиолдол нь гэрээний нөхцөлд хамаарах эсэх талаарх маргаан гарах нөхцөл байдлыг үүсгэж байна. Иймд даатгалын ангиллын ялгааг тодорхой болгох, ангиллын нэршлийг хэрэглэгчдэд илүү ойлгомжтойгоор томъёолох хэрэгцээ шаардлага бий болсон байна.

Дэд асуудал	Зорилгод хүрсэн байдал	Практикт үүсэх хүндрэл	Дүгнэлт
Урт хугацааны/ердийн ангилал	Даатгагчийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, нөөц, хяналтыг ялгах үндэс болсон.	Зээлийн хамгаалалт, амь нас-эрүүл мэндийн хосолмол бүтээгдэхүүн, хуримтлалын шинжтэй бүтээгдэхүүний ангилалд тайлбар шаардагдаж болзошгүй.	Ангилал хоорондын ялгааг тодорхой болгох.
Сайн дурын/албан журмын төрөл	Албан журмын даатгалыг тусгай хуулиар, сайн дурын даатгалын хэлбэрийг СЗХ тогтоох суурь бүрдсэн.	Зарим бүтээгдэхүүн төрөөс шаардсан мэт боловч гэрээний хувьд сайн дурын шинжтэй байх, хэрэглэгчид ойлгомжгүй тайлбарлагдах эрсдэлтэй.	Борлуулалтын үед бүтээгдэхүүний төрөл, заавал эсэх, хэрэглэгчийн сонголтыг тодорхой мэдээлэх үүрэг нэмэх.

3.4. Давхар даатгал /46-48 дугаар зүйл болон холбогдох заалт/

3.4.1. Зохицуулалтын агуулга

Даатгалын тухай хуулийн 46 дугаар зүйлд даатгагч гэрээний дагуу хүлээсэн үүргээ давхар даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан компанид, эсхүл тусгай зөвшөөрөл аваагүй гадаад улсын даатгалын компанид давхар даатгуулж болохоор зохицуулсан.

47 дугаар зүйлд даатгагч даатгалын эрсдлийг хариуцах үүргээ давхар даатгуулах төлөвлөгөөг даатгалын багц дүрэмд заасны дагуу Зохицуулах хороогоор батлуулах, мөн Зохицуулах хороо тухайн төрлийн давхар даатгалын гэрээнд төлөвлөгөө батлуулах шаардлага хамаарахгүй байхыг тогтоож болохоор заасан. 48 дугаар зүйлд даатгагч давхар даатгалын төлөвлөгөөний нарийвчилсан тайланг тогтоосон хугацаанд гаргаж, гэрээний хуулбарыг хавсарган хүргүүлэх үүрэгтэй.

Давхар даатгалын үйл ажиллагаатай холбоотойгоор хуулийн 17.4 дэх хэсэгт гадаадын даатгагчтай давхар даатгалын гэрээ байгуулах тохиолдолд давхар даатгалын төлөвлөгөөг батлуулсан, эсхүл тухайн гэрээнд төлөвлөгөөний шаардлага хамаарахгүй байхаар тогтоосон бол тусгай зөвшөөрөлгүй гадаад даатгагчтай гэрээ байгуулах зөвшөөрлийн тодорхой шаардлага хамаарахгүй байхаар зохицуулсан. Мөн хуулийн 67.1.11-д давхар даатгалын төлөвлөгөө хийгээгүй, эсхүл багц дүрмийн шаардлага хангахгүй нь албадлагын арга хэмжээ авах үндэслэл байхаар туссан.

3.4.2. Зорилгод хүрсэн түвшин

Давхар даатгалын зохицуулалт нь даатгагчийн өөрийн хөрөнгө, нөөц, төлбөрийн чадварын түвшнээс давсан эрсдэлийг шилжүүлэх, томоохон хохирол гарахад нөхөн төлбөрийн эх үүсвэрийг баталгаажуулах, даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах зорилготойгоор хэрэгжиж байна. Хуулиар дотоод болон гадаад давхар даатгагчид эрсдэл шилжүүлэх боломжийг нээсэн нь зах зээлийн эрсдэл даах чадавхыг нэмэгдүүлэх суурь болсон.

Гэхдээ Даатгалын тухай хуулийн 47.1 дэх хэсэгт “Даатгагч даатгалын эрсдлийг хариуцах үүргээ давхар даатгуулах төлөвлөгөөг даатгалын багц дүрэмд заасны дагуу Зохицуулах хороогоор батлуулна” гэж тусгасан. Уг зохицуулалт нь даатгагчийн эрсдэлийн удирдлагын бодлого, бизнесийн шийдвэр гаргалтад урьдчилсан зөвшөөрлийн шинжтэйгээр оролцож байгаа бөгөөд зах зээлийн нөхцөл байдал, эрсдэлийн түвшин, давхар даатгалын олон улсын зах зээлийн нөхцөл байдалд уян хатан, шуурхай хариу арга хэмжээ авах боломжийг хязгаарлах нөхцөл үүсгэж байна.

Практикт даатгагч нь өөрийн хөрөнгийн чадавх, эрсдэлийн үнэлгээ, багцын бүтэц, санхүүгийн тогтвортой байдалд үндэслэн давхар даатгалын бодлого, төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх нь компанийн дотоод удирдлагын үндсэн чиг үүрэгт хамаарах бөгөөд үүнд Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага хариуцлага хүлээх нь зохистой байна.

Мөн Зохицуулах хорооны үндсэн чиг үүрэг нь урьдчилан батлах бус, хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, даатгагчийн төлбөрийн чадвар, эрсдэлийн удирдлагын тогтолцоонд үнэлгээ хийхэд чиглэгдэх нь зохицуулалтын олон улсын жишиг, зарчимд нийцэхээр байна.

Иймд дээрх зохицуулалтыг урьдчилсан баталгаажуулалтын хэлбэрээс татгалзаж, даатгагч өөрийн дотоод журмын дагуу баталж хэрэгжүүлэх, харин Зохицуулах хороо хэрэгжилтэд хяналт тавих байдлаар өөрчлөх шаардлагатай гэж үзэж байна.

3.4.3. Практикт нийцэж байгаа байдал

Ердийн болон урт хугацааны даатгалын компаниуд сүүлийн таван жилийн хугацаанд нийт хураамжийн орлогын 32.7 хувьтай тэнцэх буюу 660.9 тэрбум төгрөгийг давхар даатгалын хураамж хэлбэрээр гадаад зах зээл рүү шилжүүлсэн байгаа бол давхар даатгалаас эргүүлэн олгосон нөхөн төлбөр дунджаар 65.1 тэрбум төгрөг байна. Энэ нь дотоодын даатгагчдын санхүүгийн чадавх, эрсдэлийг даах хүчин чадал хангалттай түвшинд хүрээгүй байгаатай холбоотой буюу

даатгалын үнэлгээ өндөр, томоохон эрсдэл бүхий гэрээнүүдийг дотоодын даатгагчид дангаар хүлээн авах боломжгүй тохиолдолд эрсдэлийн дийлэнх хэсгийг гадаад давхар даатгагчид шилжүүлэх тохиолдол гарч буйтай холбоотой юм.

Хүснэгт 4. Давхар даатгалын хураамжийн зардал /сая.төг/

Хугацаа	2021 он	2022 он	2023 он	2024 он	2025 он
Даатгалын нийт хураамжийн орлого	243,326.29	300,716.62	392,007.68	502,854.03	584,557.28
Давхар даатгалын хураамжийн зардал	88,378.66	101,595.89	144,164.81	165,390.50	195,513.40
Үүнээс, Дотоодын давхар даатгагчийн хураамж	4,153.30	4,084.20	6,728.60	7,697.70	11,413.70
Гадаадын давхар даатгагчийн хураамж	84,225.36	97,511.69	137,436.21	157,692.80	184,099.70
ДД хураамжийн Даатгалын нийт хураамжид эзлэх хувь	36.3%	33.8%	36.8%	32.9%	33.4%
Давхар даатгагчийн олгосон нөхөн төлбөр	4,915.21	8,776.63	16,184.73	26,155.19	35,506.07
Үүнээс, Дотоодын давхар даатгагчийн олгосон нөхөн төлбөр	1,046.66	184.51	5,802.96	15,832.25	3,558.11
Гадаадын давхар даатгагчийн олгосон нөхөн төлбөр	3,868.55	8,592.13	10,381.78	10,322.94	31,947.96

Иймд гадагш шилжүүлж буй валютын урсгалыг бууруулах зорилгоор дотоодын даатгагч нарын чадавхыг бэхжүүлэх, тэдгээрийн үйл ажиллагааг бодлогын түвшинд дэмжих шаардлагатай байгаа бөгөөд дээрх шаардлагын хүрээнд дотоодын давхар даатгалын компанид ердийн болон урт хугацааны даатгалын компаниуд эрсдэлийн тодорхой хэсгээ шилжүүлж байх шаардлагыг хуульд тусгах нь зүйтэй байна. Түүнчлэн давхар даатгагчаас өөр субъектэд эрсдэлийг шилжүүлэх, эрсдэлийг санхүүжүүлэх хөрөнгийн шинэ эх үүсвэрийг бий болгох буюу даатгалын эрсдэлд суурилсан үнэт цаас, санхүүгийн үүсмэл хэрэгсэл гаргах замаар хөрөнгийн зах зээлээс хөрөнгө босгон, даатгалын эрсдэлийг тархаан байршуулах хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх хэрэгцээ шаардлага бий болоод байна.

Мөн даатгалын үнэлгээ ихтэй даатгалын гэрээг дотоодын даатгагчид дангаар хийх боломжгүй нөхцөлд үнэлгээний дийлэнх хэсгийг гадаад даатгагчаар даатгуулах, давхар даатгагчид шилжүүлэх тохиолдлууд гарсаар байна. Иймд даатгагчид хамтран хамтын даатгал хийх, даатгалын хураамжийн зохистой хувийг дотоодод үлдээх, гадаадын даатгагчид тавих хяналт, бүртгэлийг сайжруулах хэрэгцээ шаардлага үүсэж байна.

3.5. Даатгалын маргаан шийдвэрлэлт /82, 82¹ дүгээр зүйл/

3.5.1. Зохицуулалтын агуулга

82 дугаар зүйлд аливаа этгээд даатгалын үйл ажиллагаатай холбоотой гарсан маргааныг Зохицуулах хороонд тавьж шийдвэрлүүлэх, шийдвэрийг эс зөвшөөрвөл уг шийдвэр хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш ажлын 10 хоногийн дотор шүүхэд давж заалдах эрхтэй гэж заасан. Мөн Зохицуулах хорооны шийдвэрийг давж

заалдах нь хариуцлага хүлээлгэх шийдвэрийг түдгэлзүүлэх үндэслэл болохгүй гэж зохицуулсан.

82¹ дүгээр зүйлд арбитрын хэлэлцээртэй бол даатгалын үйл ажиллагаатай холбоотой маргааныг арбитрын журмаар шийдвэрлэх бөгөөд арбитрын журмаар шийдвэрлэх тохиолдолд 82 дугаар зүйл хамаарахгүй байхаар заасан. Энэ нь даатгалын салбарын маргаан шийдвэрлэх олон сувагтай эрх зүйн орчныг бүрдүүлсэн.

3.5.2. Зорилгод хүрсэн түвшин

Маргаан шийдвэрлэлтийн зохицуулалт нь даатгалын үйл ажиллагаатай холбоотой маргааныг Зохицуулах хороо, шүүх, арбитраар шийдвэрлэх суурь боломжийг бүрдүүлсэн. Энэ нь даатгуулагч, даатгагч, бусад этгээд эрхээ хамгаалах боломжтой байх, Зохицуулах хороо салбарын хяналтын чиг үүргээ хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой.

Гэвч хуулийн зорилт болох даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах агуулгатай харьцуулахад 82 дугаар зүйл нь маргаан шийдвэрлүүлэх суваг, давж заалдах хугацааг тогтоосноос цааш гомдол гаргах хэлбэр, бүрдүүлэх баримт, шийдвэрлэх хугацаа, даатгагчид өөрсдөө дотоод гомдол шийдвэрлэх үүрэг, даатгуулагчид хариу өгөх стандарт, шийдвэрийн хэрэгжилтийг хангах механизм зэргийг хангалттай тодорхойлоогүй байна.

3.5.3. Практикт нийцэж байгаа байдал

Иргэд байгууллагуудаас Хороонд ирүүлж буй нийт өргөдөл, гомдлын нэлээдгүй хувь нь даатгалын үйл ажиллагаатай холбоотой, тэр дундаа нөхөн төлбөртэй холбоотой өргөдөл эзэлж байна. Тухайлбал, 2025 оны байдлаар иргэд, даатгуулагчдаас даатгалын үйл ажиллагаатай холбоотой нийт 475 өргөдөл, гомдлыг Хороонд ирүүлснээс 85.7 хувь нь даатгалын нөхөн төлбөртэй холбоотой өргөдөл байна. Өргөдөл гомдлын дэлгэрэнгүй тоон мэдээллийг хүснэгт 2-д харуулав.

Хүснэгт 2. Даатгалын зах зээлтэй холбоотой өргөдлийн товч утга

№	Товч утга	2023.IV		2024.IV		2025.IV	
		тоо	эзлэх хувь	тоо	эзлэх хувь	тоо	эзлэх хувь
1	Нөхөн төлбөр олгохоос татгалзсан	214	47.2%	289	61.2%	231	48.6%
2	Нөхөн төлбөр олгохгүй удаасан	158	34.9%	95	20.1%	138	29.1%
3	Нөхөн төлбөрийг хасаж олгосон	33	7.3%	42	8.9%	38	8.0%
4	Даатгалын хураамжийн маргаан	5	1.1%	5	1.1%	29	6.1%
5	Даатгалын хохирлын үнэлгээ болон бусад	43	9.5%	28	5.9%	33	6.9%

6	Даатгалын үйл ажиллагаа	0	0.0%	13	2.8%	6	1.3%
Нийт		453	100%	472	100%	475	100%

Дээрх өргөдөл, гомдлын агуулгаас үзэхэд даатгуулагч даатгалын тохиолдол гарсан үед тохиолдлыг нотлох, даатгагч, эрх бүхий байгууллагад мэдэгдэх зэрэг үүргээ биелүүлээгүй, нөхөн төлбөр авахаар бүрдүүлсэн баримт бичиг нь нотлох баримтын шаардлага хангаагүй зэргээс үүдэн даатгалын нөхөн төлбөр авах боломжгүй байдал үүсдэг байна. Гэвч нөгөө талаар, даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчийн зүгээс даатгалын бүтээгдэхүүн үйлчилгээ, даатгалын гэрээ, түүнтэй холбогдох нөхцөлийн талаарх мэдээллийг даатгуулагчид хангалттай өгөхгүй байгаа, мөн даатгагчийн санал болгож буй даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээ, гэрээний нөхцөл нь холбогдох шаардлагыг хангахгүй байгаа зэргээс үүдэн нөхөн төлбөрийн маргаан гарах нөхцөл үүсэж байна. Дээрх тоон мэдээлэл нь даатгалын үйл ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдол шийдвэрлэх ажиллагаа практикт хангалттай сайн хэрэгжиж байгааг харуулж байна.

Гэхдээ хуулийн 82 дугаар зүйлд ажлын 10 хоногийн дотор шүүхэд давж заалдах хугацааг тогтоосон боловч Зохицуулах хороонд өргөдөл гаргах хугацаа, даатгалын компаниуд эхний шатанд гомдлыг хэрхэн шийдвэрлэх, хэрэглэгчид ямар мэдээлэл өгөх, шийдвэрийн биелэлтийг хэрхэн хянах, цахимаар өргөдөл гаргах сувгийг хэрхэн ашиглах зэрэг асуудлыг илүү тодорхой болгох шаардлагатай байна.

Өөрөөр хэлбэлт, маргаан шийдвэрлэлтийн зохицуулалтыг сайжруулахдаа даатгагчид дотооддоо гомдол шийдвэрлэх нэгж/албан тушаалтан, гомдол хүлээн авах суваг, хариу өгөх хугацаа, Зохицуулах хороонд шилжүүлэх нөхцөл, шаардлагатай баримтын жагсаалт, цахим бүртгэл, шийдвэрийн хэрэгжилтийн тайлагналтай холбоотой харилцааг хууль болон холбогдох дүрэм, журмын хүрээнд уялдуулах нь зүйтэй.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Даатгалын тухай хууль нь Монгол Улсын даатгалын зах зээлийн тогтвортой байдлыг хангах, даатгалын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн тогтолцоо, төрийн хяналт, зохицуулалт, даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах үндсэн зорилтуудыг хангах суурь эрх зүйн орчныг бүрдүүлсэн байна.

Тус хууль батлагдан хэрэгжсэнээр даатгалын салбарын үйл ажиллагааг нэгдсэн эрх зүйн хүрээнд зохицуулах, зах зээлийн оролцогчдын эрх, үүргийг тодорхой болгох, санхүүгийн чадавх, төлбөрийн чадварын суурь шаардлагыг тогтоох, даатгуулагчийн эрх ашгийг хамгаалах үндсэн механизмыг бий болгох замаар тухайн үеийн зах зээлийн хөгжлийн тодорхой шатанд чухал ач холбогдолтой үүрэг гүйцэтгэсэн. Энэ эрх зүйн орчны үр дүнд даатгалын зах зээл өргөжин тэлж, бүтээгдэхүүн үйлчилгээний төрөлжилт нэмэгдэн, зах зээлийн хамрах хүрээ өргөжиж, эрсдэлийг удирдах суурь механизм бүрэлдэх зэрэг хөгжлийн үндсэн суурь нөхцөл боломжууд бүрдсэн.

Гэсэн хэдий ч хууль хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд даатгалын зах зээл бүтэц, хамрах хүрээ, үйлчилгээний хэлбэрийн хувьд өргөжин хөгжихийн хэрээр цахим үйлчилгээ, даатгагчийн баталгаа, эрсдэл шилжүүлэх уламжлалт бус арга хэрэгсэл зэрэг шинэ төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, борлуулалтын олон суваг нэвтэрч, түүнийг дагаад даатгуулагчийн эрх ашгийг хамгаалахтай холбоотой эрх зүйн орчныг сайжруулах хэрэгцээ шаардлага бий болсон байна. Энэ нь хуулийн зарим суурь зохицуулалтыг өнөөгийн зах зээлийн хэрэгцээ, олон улсын сайн туршлага, зохицуулалтын чиг хандлагатай нийцүүлэн дахин үнэлэх шаардлагыг бий болгож байна. :

1. Хуулийн зорилго, хамрах хүрээ болон нэр томъёоны зохицуулалт нь салбарын эрх зүйн үндсэн ойлголтыг тогтоосон хэдий ч цахим техник технодогид суурилсан бүтээгдэхүүн, үйлчилгээ, даатгагчийн баталгаа болон хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах асуудлыг илүү тодорхой, нарийвчилсан байдлаар тусгах хэрэгцээ байна.
2. Хуулийн 6 дугаар зүйлд тусгагдсан бүтээгдэхүүний ангилал, төрөл, түүнтэй холбоотой зохицуулалт нь суурь тогтолцоог бүрдүүлсэн боловч урт хугацааны даатгалын үйл ажиллагааг хуулиар нарийвчлан зохицуулж, холбогдох зохицуулалтыг сайжруулах шаардлагатай байна.
3. Хуулийн 46–48 дугаар зүйлд тусгагдсан давхар даатгалын зохицуулалт нь эрсдэл шилжүүлэх үндсэн механизмыг тогтоосон боловч давхар даатгагчаас өөр этгээдэд эрсдэл шилжүүлэх буюу эрсдэл шилжүүлэх уламжлалт бус арга хэрэгсэл, хамтын даатгалын зохицуулалтыг хууль тусгах шаардлагатай. Түүнчлэн, даатгалын хураамж хэлбэрээр гадагш шилжүүлж буй валютын урсгалыг бууруулах зорилгоор дотоодын давхар даатгалын компанид ердийн болон урт хугацааны даатгалын компаниуд эрсдэлийн тодорхой хэсгээ шилжүүлж байх шаардлагыг хуульд тусгах нь зүйтэй байна.
4. Давхар даатгалын төлөвлөгөөг урьдчилсан баталгаажуулалт хийх зохицуулалтаас татгалзаж, даатгагч өөрийн дотоод журмын дагуу баталж хэрэгжүүлэх, харин Зохицуулах хороо хэрэгжилтэд хяналт тавих байдлаар өөрчлөх шаардлагатай.
5. Хуулийн 82, 82¹ дүгээр зүйлд маргаан шийдвэрлэх эрх зүйн үндсийг тогтоосон хэдий ч гомдол шийдвэрлэх шат дараалал, хугацаа, хэрэглэгчийн мэдээлэл авах эрх, шийдвэрийн хэрэгжилт зэрэг харилцааг илүү тодорхой болгох шаардлагатай байна.

ТАВ. АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Хууль, эрх зүйн акт

1. Хууль тогтоомжийн тухай хууль, 2015 он.
2. Иргэний хууль, 2002 он.
3. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоол;
4. Даатгалын тухай хууль, 2004 он.
5. Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль, 2004 он.
6. Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль, 2005 он
7. Малын индексжүүлсэн даатгалын тухай хууль, 2014 он
8. “Алсын хараа-2050”, 2020 он
9. Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2024 он
10. Монгол Улсыг 2026-2030 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, 2025 он

Статистик мэдээ, судалгааны тайлан

1. Санхүүгийн зохицуулах хорооны Өргөдөл, гомдлын судалгааны тайлан, 2021-2025 он
2. Санхүүгийн зохицуулах хорооны Даатгалын салбарын үйл ажиллагааны нэгдсэн тайлан, 2021-2025 он